

**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**
/Жилийн эцэс/

2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

№	Үүрэг	Хэрэгжилт	Үнэлгээ /%/
1	Барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.	Паркийн 250 га газар дээр нийт 35 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар 18 аж ахуйн нэгжтэй шинэ гэрээ хийсэн. Шинэ гэрээ хийсэн 11 аж ахуй нэгжүүрүү бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, бичиг баримт, зураг төслийн бүрдлийг хангах албан бичиг хүргүүлсэн. 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт хашаа барин үйлдвэрийн барилга байгууламжаа барих бэлтгэл ажлыг хангаад байна. 6 аж ахуйн нэгж нь хар, цагаан замаска 1056 тн, ширэх болон ган боловсруулах 150 тонн утас, 400 тонн ган бөмбөлөг, хар тугалган хүхрийн хүчлийн батарейг байгаль орчинд ээлтэй технологиор дахин боловсруулсан байна. Үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр нь нийслэлийн дүүргүүдийн татвар 941,000,000 сая төгрөгийн татвар төллөж 174 иргэнийг түр болон байнгын ажлын байраар ханган, ажиллаж байна.	100
2	Хөрөнгө оруулалтыг дэмжих.	Цахилгаан хангамжийн БУ-ын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Уг барилга байгууламжийн “Налайх 110/35/10 кВ-ын дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” бүрэн дууссан, дэд станцаас Паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” бүрэн дуусаж техникийн комисс ажилласан. Дэд станцаас паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт 9,8 км цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил бүрэн дуусаж агаарын шугамын хүчдэлээ өгч техникийн комисс 72 цагын туршилт тохируулга амжилтай хийгдэж улсын комисс ажиллаж тайж дэд станцыг хүлээж авсан. 2026 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд дэд бүтцийн ажлуудыг тусгуулахаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүүд саналаа хүргүүлсэн. Мөн Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд паркийн 1000 м3 цэвэрлэх байгууламж тусгагдсан. Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөөр цэвэрлэх байгууламжийг 1,8 га дээр төлөвлөсөн. Барилга байгууламж стандарт норм аюулгүйн бүсийг тооцож үзэхэд төлөвлөгдсөн газрын хэмжээ бага байгаа тул Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх 20 га газрын хүсэж албан хүсэлт хүргүүлсэн.	100

3	Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг босгох.	Цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтыг төр хувийн хэвшлийн түншлэлээр хийх хэлэлцээр хийж байна. Мөн бусад дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийлгэр хууль эрх зүйн орчин эдийн засгийн үр ашгийн тооцоол хийгээр төлөвлөж байна.	100
4	Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулах, үйл ажиллагаа эрхлэх.	"Сайнхан улаан оргил" ХХК нь том машины 30,000 ш хаягдал дугуй дахин боловсруулж 1126тонн резиний үйрмэг болгон экспортод гаргасан. Мөн 400тонн тросс буюу хаягдал төмрийг дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн.	100
5	Паркийн салбар барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн үйл ажиллагаа эрхлэх.	Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төв-ын 60 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Хот байгуулалт, Хотын стандартын газрын 2026 оны зураг төсвийн төлөвлөгөөнд тусгуулсан.	100
6	Компани нь зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн явуулна.	Паркийн Хөгжлийн төлөвлөгөө /2025-2040/-г боловсруулан хүлээн авч Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Хөгжлийн төлөвлөгөөг АҮЭБЯ-ын мэргэжлийн зөвлөлөөр батлуулж, паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Мөн тусгай зөвшөөрөл авахад шаардагдах аж ахуйн нэгжийн БОНУ, ТЭЗҮ, ХЕТ, ТТҮ-ний бүрдлийг хангасан.	100
7	Цэцэрлэгжүүлэг, ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхлэх	Байгууллагын ногоон байгууламжийн 34 ширхэг мод, 20 гаруй бут сөөгийн арчилгааг тогтмол хийн, шар өвсийг түүж цэвэрлэн 2мкв гадна талбайд цэцэг тарьсан. Мөн Налайх дүүргийн "Шинэ-Налайх" цэцэрлэгт хүрээлэнд 36 ширхэг хайлаас модыг шинээр тарьж суулгасан. Гэрээ хийсэн үйлдвэрүүдийн газрын 30% нь ногоон байгууламж болгох хэрэгжүүлж ажиллаж байна.	100
8	Бусад хууль, тогтоомжоор олгогдсон үүргийг хэрэгжүүлж ажиллана.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн хэрэгжилтийн тайланг тухай бүрт нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажиллаж байна. Мөн Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагаж мөрдөх журмын төсөлд санал хүргүүлэн ажилласан.	100

ХЯНАСАН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

20.25 оны 12 сарын 12-ны өдөр

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ПҮРЭВСҮРЭН

Х.БЯМБАА